





**БГД 29-Р ХОРОО, ТЭЦ-4 БАРУУН ТАЛД ШИНЭЭР ХОЛБООНЫ ХУДАГ
СУВАГЧЛАЛ БАЙГУУЛАХ АЖЛЫН
ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**
/..З...ХУУДАС/

ТАНИЛЦСАН:



А.ГАНТУЛГА
ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

Ц.ОДХҮҮ
СТРАТЕГИ, САНХҮҮ БОРЛУУЛАЛТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

ХЯНАСАН:



С.ЗОЛЖАРГАЛ
ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:



Т.НАРМАНДАХ
ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

**СУВАГЧЛАЛ ШИНЭЭР СУУРИЛУУЛАХ
ТЕХНИКИЙН ДААЛГАВАР ТД-2024/07**

2024.01.19

1. **Өргөтгөл хийх чиглэл:** Баянгол дүүргийн 29-р хороо, ХШ-6809 хүрээнд, ТЭЦ-4 эрчим хүчний гудамж, Хөсөг трейд, Говь-2 компанийн баруун талаар шинээр худаг сувагчлал хийх.
2. **Өргөтгөл хийх болсон шалтгаан:**
 - Худаг сувагчлалын бэлэн байдлыг хангуулах, шинээр 2+0 эгнээ хоолойг хийж сувагчлал өргөтгөх.
3. **Техникийн үндсэн нөхцөл:**
 - ХШ-6809 хүрээний Эрчим хүчний гудамжны авто замын дахин төлөвлөлтөөр хийгдэх холбооны сувагчлалтай уялдуулан шинээр төлөвлөж буй авто замын урд талд ТБУХ-1 стандартын шинэ худаг /ШХ-1/ суурилуулан авто зам хөндлөн гаргаж 2+0 эгнээ бүхий худаг сувагчлалыг шинээр угсарч суурилуулна.

Үүнд:

- Нийт PVC ф-110 мм-ийн 2+0 эгнээ хоолой бүхий 424 метр сувагчлал шинээр хийх.
 - Нийт ТБУХ-1 стандартын худаг 6 ширхэгийг шинээр суурилуулах.
 - Шинээр суурилуулах ШХ-1-ээс 26 метр урт асфальтан авто замыг хөндлөн буудна.
 - Авто зам хөндлөн буудах хэсэгт ф-273 мм-ийн ган хоолой 26 метр хийж түүгээр PVC 110 мм-ийн диаметртэй 2+0 эгнээ хоолойг сүвлэн ШХ-2-той холбоно.
 - ШХ-2 худгаас хойш 110мм-ийн диаметртэй PVC 2+0 эгнээ хоолой бүхий худаг сувагчлалыг хийх.
 - Инженерийн шугам сүлжээ хөндлөн гарч буй хэсэгт 15 метр ф-273 мм-ийн ган хоолойд 2+0 эгнээ PVC хоолойг хийж хамгаалж өгнө.
 - 424 метр хамгаалалтын туузыг дэвсэж булаах.
- 3.1 Угсралтын ажил эхлэхээс өмнө ажлын зураг, техникийн даалгаврын дагуу хийгдсэн эсэхийг МХС ХХК-ийн Технологийн удирдлага, төлөвлөлтийн газрын холбогдох ИТА-аар хянуулж баталгаажуулна.
 - 3.2 Худаг сувагчлалын угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.

4. Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:

- 4.1 Худаг сувагчлалын угсралтын болон газар шорооны ажлыг эхлэхдээ Технологийн удирдлага, төлөвлөлтийн газраас ажил эхлүүлэх зөвшөөрлийг авсан байна.
- 4.2 Угсралтын ажлын явцыг МХС ХХК-иас томилогдсон инженерийн хяналтан дор Монгол Улсад мөрдөгдөж байгаа **MNS 6668:2017** стандартыг баримтлан ажиллана.
- 4.3 Угсралтын ажлыг хийж гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нарийн чанд баримталж ажиллана.

4.4 Угсралтын ажил дууссаны дараа сувагчлалын трассыг МХС ХХК-ийн ТУТГазрын Чанар хяналтын хэлтэст техникийн актны хамт хүлээлгэн өгч мэдээллийн санд тусгуулна.

4.5 Улаанбаатар хотын мэдээллийн санд тусгуулна.

4.6 Угсралтын ажлын явцад захиалагч байгууллагын хяналтан дор технологийн шаардлагыг бүрэн хангуулж ажиллана.


5. Угсралтын явцад анхаарах технологийн нэмэлт шаардлагууд:

5.1 Газар шорооны ажлын үед бусад инженерийн шугам сүлжээг гэмтээхээс сэргийлж тодруулга авч, давхцаж, хөндлөн огтолж байгаа тохиолдолд зөвшилцөн хамгаалах арга хэмжээ авч ажиллана.


5.2 Авто зам, явган хүний зам болон тохижсон зам талбай дээр газар шорооны ажил хийхээр бол холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч, авто замаар сувагчлалыг гаргахдаа "Авто зам, төмөр зам хөндлөн гарах болон гүүрэн байгууламжинд холбооны кабель шугамыг суурилуулах" ерөнхий шаардлага **MNS 6597:2016** стандартыг баримтлаж ажиллана.

5.3 Худаг сувгийн суурилуулалтын ажлыг MNS6668:2017 стандартад дурьдагдсан дараах технологийн шаардлагуудыг мөрдлөгө болгон ажиллана.

5.3.1 Сувагчлалын хоолойг зурагт заасан байрлалаар суурилуулна.



5.3.2 Газар шорооны ажлыг дараах технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.




5.3.3 Худаг хоорондын хоолойг дараах технологийн дагуу угсарч суурилуулна. Хотгор суурилуулахыг хориглоно.



5.3.4 Инженерийн байгууламжтай зэрэгцээ болон хөндлөн огтлолцож байгаа тохиолдолд MNS 6668:2017 стандартын 5-р зүйлийг баримталж ажиллана.

5.3.5 Авто замын саадыг сэтэлж ухахгүйгээр хэвтээ чигт суваг өрөмдөх технологиор ф-273мм-ийн диаметртэй суурилуулах технологи ашиглана. Өрөмдөгч машины хошуу нь газрыг өрөмдөхдөө өрөмний диаметрийн хэмжээтэй нүх гаргах ба шороогоо гадагш нь гаргахгүйгээр гадна хананд нь нягтруулан шахах замаар газар доогуур өрөмдөнө.




5.3.6 Төмөр бетон угсармал худаг (ТБУХ-1) маркийн стандарт худгаар төлөвлөнө.

Төмөр бетон угсармал худгийн хэмжээ

		ТБУХ-1	ТБУХ-2	ТБУХ-3	
1	Худгийн дотор зайн урт	А /см/	180	220	280
2	Худгийн дотор зайн өргөн	Б /см/	100	110	140
3	Худгийн дотор зайн өндөр	В /см/	180	200	220
4	Худгийн хананы зузаан	Г /см/	8	10	10
5	Худгийн ероолын хавтангийн зузаан	Д /см/	8	8	10
6	Худгийн тагны хавтангийн зузаан	Е /см/	50	60	60
7	Худгийн яндангийн оролт гаралтын нүхний өндөр	Ё /см/	40	50	70
8	Худгийн нүхний дээд түвшин	Ж /см/	50-60	60-80	60-80
9	Худгийн нүх гаргах дотор хананы өргөн	З /см/	60	70	90
10	Худгийн нүх гаргах дотор хананы урт	К /см/	100	120	180
11	Эзэлхүүний дотор	м ³	2.95	4.44	8.07

Холбооны худаг



БГД 29-р хороо. ТЭЦ-4 баруун талд шинээр холбооны
худаг сувагчлал байгуулах

